

## **Л.Пүрэвдорж: Одоо л засахгүй бол Грек, Италийн араас орж мэднэ**

*Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржтой ярилцлаа.*

**-Ирэх оны төсөв батлагдчихлаа. Нэгэнт хөдөлчихсөн галт тэргийг зогсоох боломж байхгүй. Гэхдээ Монголбанкны ерөнхийлөгчийн таалалд ирэх оны төсөв хэр нийцсэн бол?**

-Төсөв батлагдахын өмнө Монголбанк байр сууриа илэрхийлсэн. Дэлхийн банк, ОУВС ч төсвийг ингэж тэлж болохгүйг сануулсан.

УИХ төсвийн зарлагыг багасгасан ч төсөв том хэвээр байгаа. Төсвийн 33 хувийг ард иргэдэд бэлнээр тараах мөнгө эзэлж байна шүү дээ. Түүнээс гадна цалин, тэтгэвэр тэтгэмжийг огцом нэмж байна. Энэ нь зөвхөн ирэх онд бус, дараа оны төсөвт ч ачаалал өгнө. Ер нь төсвийн бүтэц ирэх жилүүдийн хөгжилд таагүй харагдаж байгаа.

**-Та “Зарлагыг нэг их наяд орчим төгрөгөөр бууруулбал бид инфляцыг нэг оронтой тоонд байлгана” гэж хэлсэн. Хоёр оронтой тоог даваад явсан инфляцыг бууруулах боломж бий юү?**

-Зарлагыг нэг их наядаар бууруулбал инфляцыг 10 хувьд барина гэж Монголбанкнаас мэдэгдээгүй. Инфляцыг 10 орчим хувьд барих боломж байна, түүнийгээ ашиглая гэж хэлж байгаа юм. Ямар ч тохиолдолд инфляцыг ийм төвшинд барих учиртай. Үүний төлөө бүх боломжоо дайчлах хэрэгтэй юм. Энэ бол зөвхөн Монголбанкны зорилт биш, эдийн засгийн чухал зорилт. Үүнээс хэтэрвэл ард иргэдийн амьдралд, эдийн засгийн хөгжилд муу нөлөө үзүүлнэ.

УИХ-аас төсвийн зарлагыг 784 тэрбум төгрөгөөр бууруулж баталлаа. Гэхдээ инфляцыг 10 орчим хувьд барих боломж харагдаж байгаа.

**-Тэгэхээр инфляц нэг оронтой тоонд хүрнэ гэдэг бол мөрөөдлийн зүйл байх нь ээ?**

-Мөрөөдлийн гэж хэлж болохгүй. Мөнгөний бодлогыг чангаруулахаас өөр аргагүй ч зөвхөн түүгээр инфляцыг шийдэхгүй. Цаана нь олон хүчин зүйл бий. Тухайлбал, энэ жилийн инфляцын 30 орчим хувийг махны үнэ бүрдүүлж байгаа. Тэгэхээр махны нийлүүлэлтийг сайжруулаад үнийг өнгөрсөн оны төвшинд аваачвал инфляцыг 2-3 нэгжээр бууруулах боломж бий гэх мэтээр.

**-Иргэн бүр сая төгрөгтэй тэнцэх хэмжээний хувьцаа эзэмших, эсвэл үүнтэй тэнцэх мөнгөө авч болно гэсэн хоёр сонголт байгаа. Ийм нөхцөлд мөнгөний бодлогыг сулруулах боломж харагдахгүй байна. Та сая мөнгөний бодлогыг цаашид улам чангаруулна гэж хэллээ. Мөнгөний хатуу бодлого хэдий болтол үргэлжлэх юм бэ?**

-Мөнгөний бодлогыг сулруулна гэдэг бол хөгжлийн чухал асуудал. Гаднаас чиглэсэн хөрөнгийн урсгал их, байгалийн баялгаас хараат байгаа үед мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх учиртай. Өөрөөр хэлбэл, бодлого ерөнхийдөө хатуувтар, тэр дотроо төсвийн бодлого хатуу, мөнгөний бодлого сулавтар байвал үр дүнтэй юм. Гэтэл эсрэг

байна. 2013 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг мөрдөх үеэс энэ байдлаа засах хэрэгтэй.

Яахав, ирэх оны төсвийн зарлагаас 800-аад тэрбум төгрөгийг хаслаа, амьдрах гээд үзье, тал талаасаа хичээе. Харин үүнээс хойш энэ загвараар явбал бид баялгийн хараалд өртөнө.

**-Мөнгөний бодлого, сангийн бодлого хоёр уялдах ёстой гэдэг. Гэтэл манайд нэг нэгнээ “дарангуйлах” байдлаар яваад байх шиг санагддаг. Эдийн засаг их халж байгаа үед энэ хэвээр байвал ихээхэн эрсдэлтэй тулгарах юм биш үү?**

-Байгалийн баялгаа ашиглан эрчимтэй хөгжиж буй энэ тааламжтай үедээ бид аль болох хэмнэлттэй хандаж, орлогынхоо тодорхой хэсгийг нөөцөлж явах хэрэгтэй. Гэтэл Засгийн газар улс төрийн амлалтад чирэгдэж төсвөө томсгоод байдаг, Монголбанк төсвөөр үүссэн нөхцөлийг мөнгөний бодлогоор залруулах гэж зүтгээд байдаг. Өөрөөр хэлбэл, макро бодлогын зохистой хослол алдагдчихаад байна гэсэн үг. Үүний цаад шалтгаан нь улс төрийн амлалт болчихоод байгаа юм.

**-Одоогийн төсвийн бүтэц цаашид сайн нөлөө үзүүлэхгүй гэлээ. Улс төрийн амлалтаа биелүүлэх гэж улайрч байгаа нөхцөлд ямар гарц байж болох вэ?**

-Улстөрчид амлахаа болих хэрэгтэй. Монголын эдийн засаг улс төрийн амлалтыг даахгүй. Үүний тулд Сонгуулийн хуулиа өөрчлөх хэрэгтэй.

**-Эдийн засаг ирээдүй цагт их сайхнаар төсөөлөгдөж байгаа. Энэ сайхан үгээр иргэдийн толгойг эргүүлж одоогийн үүсээд буй бодит байдлыг тэднээс холдуулаад байх шиг. Жирийн иргэдэд дарамт болж байгаа инфляцын гол үйлдвэрлэгч нь Засгийн газар гэх юм. Зарим нэг нь танайхыг ч буруутгаж байгаа. Үүнд ямар тайлбар өгөх вэ?**

-Ирээдүй бол маш сайхан харагдаж байгаа. Гэхдээ энэ сайхан зүйл нь аяндаа бий болчихгүй. Үүнийг зөв удирдах хэрэгтэй. Удирдлага нь оновчгүй бол хэрэгжих боломжгүй.

Монголбанк хэтэрхий хатуу бодлого явуулж байна гэдэгтэй санал нийлэхгүй. Бид зөвхөн инфляцыг онилоод зүтгээд байгаа юм биш. Гэвч цаашид мөнгөний бодлогыг хатууруулах шаардлага бий.

**-Банкууд зээлээ хумьж байна. Зарим банк зээлийн эрэлтээ гүйцэхгүй байгаагаа мэдэгдсэн. Санхүүгийн зах зээлийн энэ орон зай эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээ хадгалж чадах уу?**

-Энэ онд зээлийн хэмжээ 61 хувиар өсөөд байгаа. Хувийн хэвшил дотоод хуримтлал багатай, банкны зээлээс хамааралтай учраас тэд бас халалтад автаж байна. Тийм учраас банкууд зээлээ багасгаж байгааг зөв алхам гэж үзэж байгаа. Зээл олдож байгаагаар, бизнес тэлж байгаагаар хамаагүй “давхиж” болохгүй. Ер нь жолоогоо татах нь зүйтэй. 2012 оны хувьд зээл рүү хошуурч түүнд тулгуурласан бизнест хэт анхаарвал эрсдэлтэй гэдгийг хэлмээр байна.

**-Хөгжлийн банк бонд гаргана гэдгээ албан ёсоор зарлалаа. Хямралын энэ үед цагаа олоогүй гэж шүүмжлэх хүмүүс цөөнгүй байна.**

-Нэгдүгээрт, Хөгжлийн банкны бонд төсвийг орлож болохгүй. Хоёрдугаарт, сайн төслийг санхүүжүүлэх хэрэгтэй. Гуравдугаарт, хэрэгжсэн төслүүд нь хөрөнгө оруулалтынхаа үр дүнгээр төлөгдөх ёстой. Эдгээр шаардлагыг зөрчвөл хүнд нөхцөлтэй тулгарна.

**-Танайх Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хяналт тавина биз дээ.**

-Манайд хамаарахгүй. Засгийн газар хяналт тавина.

**-Засгийн газрын бондыг дотоодын биржид арилжиж байгаа. Хөгжлийн банкны бондны эхнийхийг энэ сардаа багтаан гадаад зах зээлд гаргана гэсэн. Гэтэл хөрөнгө оруулалтаа хийж удирдах байгууллагаас бонд гаргах нь зөв, Засгийн газар бонд гаргаснаар өр л нэмэгдэнэ гэх яриа үүсээд байгаа. Ийм зөрчилтэй яриа нь бондын өгөөжинд ямар нэгэн нөлөө үзүүлэх болов уу?**

-Зөрчил гарч болно. Хэрэв Засгийн газар гадаад зах зээл рүү бонд гаргавал баталгаажуулсан Хөгжлийн банкныхаа бондын өртгийг өсгөж магадгүй.

**-Тавантолгойн IPO-г ирэх оны эхний улиралд гаргана. Үүнийг шингээх чадвар дотоодод хэр байгаа бол. Мөн уул уурхайн импорт огцом өсөж байгаа. Энэ бүхэн ханшийн хүчтэй савлагааг бий болгох юм биш үү?**

-Тавантолгойн IPO-г хийгээд 2.3 тэрбум ам.долларын хувьцааг мөнгөжүүлнэ гэж байгаа. Гаднаас орж ирсэн мөнгөнийхөө хэрээр цацаад эхэлбэл ирэх онд төсвийн тэнцвэр алдагдана. Ханшийн савлагаа, инфляцын нөлөө их бий.

IPO хийгээд орж ирсэн мөнгийг хөрөнгө оруулалтад зарцуулах хэрэгтэй. Түүнээс өөр зүйлд зарцуулах ёсгүй. Энэ бол чухал зарчим юм.

**-Хувьцааг мөнгөжүүлэх тухай ярьж байгаа атлаа танайхтай зөвлөдөггүй юм уу?**

-Биднээс асуусан зүйл алга. Мөнгөний бодлоготой холбоотой асуудал учраас бид санаачилгаараа ханддаг.

Энэ мөнгө төсвөөс гадуур явж байгаа. Ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх нь тодорхойгүй гэсэн үг. Уг нь төсвийн бүрэлдэхүүн хэсэгт багтах учиртай.

Монголбанк хувьцааг мөнгөжүүлэх ажлыг 5-6 жилийн хугацаанд хийх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Гэхдээ ирэх онд үүнийг 100 тэрбум төгрөгөөс хэтрүүлэхгүй байх хэрэгтэй гэж үзэж байна. Энэ саналыг УИХ дахь Ажлын хэсэгт хүргүүлээд байгаа. Үүний цаана ямар аюул хүлээж байгааг би дээр хэлсэн шүү дээ.

**-Ирэх жил цалин 53 хувиар өснө гэдэг бол иргэдэд сайн мэдээ. Гэхдээ хөдөлмөрийн бүтээмжтэй уялдаагүйгээр нэмж буй нь мөнгөний үнэ цэнийг улам унагаж байна. Цалинг яаж нэмбэл эдийн засагт сөрөг нөлөө бага байх байсан бол?**

-Монголбанк цалин нэмэхийн эсрэг зогсоогүй. Харин бүтээмжтэй уялдаж, Монголд бий болж буй орлогынхоо чадамжтай зохицох ёстой гэж үзэж байгаа. Уул уурхайн орлогоосоо үүнийг санхүүжүүлээд явбал яваандаа эх үүсвэргүй болж мэднэ.

Цалин нэмэхээр инфляцад асар их нөлөөлнө. Хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдэх боломжийг хаана. Нийт бүтээгдэхүүний өртөг доторх цалингийн зардлын хувийн жинг огцом өсгөхгүй байж өрсөлдөх чадвараа хадгална. Цалингийн хэмжээ бүтээмжтэй уялдаагүй нэмэгдчихээр Монголын өрсөлдөх чадвар бүхэлдээ муудчихаж байгаа юм.

**-Та түрүүн хэмнэлттэй хандах бодлого гэж ярилаа. Хямрал тохиолдлоо гэхэд бидэнд ямар нөөц байгаа вэ. Европын хямрал Ази руу шилжвэл бидэнд хийх тариа бий юү?**

-Хямрал болбол бид инфляцтай, зогсонги байдалтай л тулгарна. Одоогийн нөхцөлөө засаж явахгүй бол Итали, Грекийн араас орж ч мэднэ. Хямрал эхэлбэл зохицуулалтын арга хэмжээ түргэн авах шаардлагатай. Хамгийн түрүүнд төсвөө танах асуудал үүснэ.

**-Ийм зүйл тохиолдлоо гэхэд Төвбанкны ерөнхийлөгч юуг амлаж чадах вэ. Инфляц арай ч 33 хувьд хүрэхгүй байх, тийм ээ?**

-Яасан ч хүргэхгүй.

**-Монголбанкны үйл ажиллагаанд аудит хийгээд 254 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Танайх өөрсдийн үйл ажиллагаагаа хянаж чадахгүй байгаа нь юутай холбоотой вэ?**

-Монголбанкны алдагдал хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, валютын ханшийн зөрүүнээс 180-аад тэрбум төгрөг, хоёрдугаарт, өнгөрсөн жил гаргасан 1.1 их наяд төгрөгийн үнэт цаасны хүүнээс 60-аад тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн. Энэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн бодлого, мөнгөний нийлүүлэлтийг саармагжуулан инфляцыг бууруулах бодлогоос үүдсэн зардал юм. Өөрөөр хэлбэл, Монголбанкны зардал гэхээс илүү Монголын эдийн засгийн зохицуулалтын зардал гэж ойлгож болно.